



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/663

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4, 23.1.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XIV/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод “AIRAGDAY” нэгдсэн арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

- Дарга: - Д.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд: - М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
- Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
- Г.Алтанцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)
- Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
- А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
- Ц.Бүрэнтуяа (Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга)
- Г.Алдармөнх (Соёл урлагийн газрын дарга)
- Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар)
- Г.Ганбаяр (Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа)
- Сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: - Г.Бямбажаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

3. “AIRAGDAY” арга хэмжээг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, удирдлага арга зүйгээр ханган, чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Д.Алтаншагай)-г үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010827